

## Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийг ангилахуй

**Цэвээний Цэцэнбилэг, доктор (Ph.D), дэд профессор**  
*Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн*  
*Улаанбаатар, Монгол Улс, [tsetsenbilegts@gmail.com](mailto:tsetsenbilegts@gmail.com)*  
<https://orcid.org/0000-0001-5987-9390>

**Жаргалсайханы Пүрэвханд, магистр**  
*Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн*  
*Улаанбаатар, Монгол Улс, [j.purevkhand@gmail.com](mailto:j.purevkhand@gmail.com)*  
<https://orcid.org/0000-0002-9578-3305>

**Норовжамцын Мөнхбат, докторант**  
*МУИС-ийн Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн*  
*удирдлагын сургууль, Улаанбаатар, Монгол Улс*  
[nmuba99@gmail.com](mailto:nmuba99@gmail.com); <https://orcid.org/0009-0003-3274-9462>

### Article history

Received : 2024-08-31  
Accepted : 2024-09-28  
Published : 2024-12-20

### Түлхүүр үгс

*албан бус эдийн засаг,  
салбар, хөдөлмөр  
эрхлэлт,  
албан бусын  
тодорхойлолт*

### Keywords

*informal economy,  
sector;  
employment,  
labor,  
informality definition*

**Хураангуй:** Албан бус хөдөлмөр эрхлэлт нь социалист систем задран унаснаас хойш Монгол Улсад бий болсон. Уг өгүүлэл нь Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хийгдсэн судалгааг тоймлон 2022-2023 онд 5 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 1002 албан бус ажил олгогчдын дунд явуулсан социологийн судалгааны үр дүнг танилцуулах зорилготой юм. Тус судалгаанд Зигмант Бауман, Роберт Рейх нарын онолыг онолын суурь болов. Гэсэн хэдий ч хээрийн судалгааны явцад олж авсан тоо баримтаас харахад Монголын албан бус хөдөлмөр эрхлэлт илүү олон янз байгааг харуулж байна.

### Toward to issues of classification the Mongolian informal employment

**Tsetsenbileg Tseveen (Ph.D), associate prof**  
*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences*  
*Ulaanbaatar, Mongolia, [tsetsenbilegts@gmail.com](mailto:tsetsenbilegts@gmail.com)*  
<https://orcid.org/0000-0001-5987-9390>

**Purevkhand Jargalsaikhan (MA)**  
*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences*  
*Ulaanbaatar, Mongolia, [j.purevkhand@gmail.com](mailto:j.purevkhand@gmail.com)*  
<https://orcid.org/0000-0002-9578-3305>

**Munkhbat Norovjamts (Ph.D candidate student)**  
*School of Political Science, International Relations & Public*  
*Administration, NUM, Ulaanbaatar, Mongolia*  
[nmuba99@gmail.com](mailto:nmuba99@gmail.com); <https://orcid.org/0009-0003-3274-9462>

© The Author(s), 2024



**Abstract:** The informal employment in Mongolia had appeared since collapse of the socialist system. The article aimed to outline the concept, observe the studies in area of informal employment in Mongolia and present the results of the sociological survey conducted in 2022-2023 among 1002 informal employers in 5 provinces and capital Ulaanbaatar. The theory of Zigmant Bauman and Robert Reich are referred as theoretical background. However, the data obtained during the fieldwork suggest about more diversities of informal employments in Mongolian.

Албан бус хөдөлмөр эрхлэлт нь социалист систем задран унаснаас хойш Монгол Улсад бий болсон. Уг өгүүлэл нь Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хийгдсэн судалгааг тоймлон 2022-2023 онд 5 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 1002 албан бус ажил олгогчдын дунд явуулсан социологийн судалгааны үр дүнг танилцуулах зорилготой юм. Тус судалгаанд Зигмант Бауман, Роберт Рейх нарын онолыг онолын суурь болов. Гэсэн хэдий ч хэрийн судалгааны явцад олж авсан тоо баримтаас харахад Монголын албан бус хөдөлмөр эрхлэлт илүү олон янз байгааг харуулж байна.

Албан бус хөдөлмөрийн тухай нэр томъёо харьцангуй шинэ бөгөөд Британийн антропологич Кейт Хартын судалгаа (Hart, 1973) үүнийг “хөдөлмөрийн нөхцөлийг оновчтой болгох зэрэглэлийг” онцолж, анх 1971 онд албан бус эдийн засаг гэсэн нэр томъёог Гана улсын Аккра дахь ядуу хүмүүсийн энгийн хөдөлмөрийг тодорхойлоход ашигласан (Hart, 1973; Geertz, 1963). Харт жижиг хэмжээний, бүртгэлгүй ажлын байр нь орчин үеийн эдийн засгийн чухал хэсэг болохыг олж мэдсэнээр “уламжлалт салбар” гэсэн нэр томъёог “албан бус салбар”-аар солих болсон.

“Албан бус”-ын талаарх хэлэлцүүлэг ХХ зууны хувьд шинэ байж нэр томъёог нэвтрүүлэн хөгжил, уламжлалт, орчин үеийн, хоцрогдол,

ядуурал, эрсдэл, хамгаалал, жендер, арьс өнгөний үзэл, шошгожилт, маргинал, тогтворгүй байдлыг хөдөлмөр эрхлэлттэй холбогдон өдгөө хагас зууны нүүрийг үзжээ. ХХI зуунд түүх, нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн жамаар ажилчид болон хөдөлмөрийн хөдөлгөөн шинэ сорилтуудтай нүүр тулж “албан бус”-ын талаарх хэлэлцүүлэг мөн даяаршил, дэлхий нийтийн тогтворгүй, таахад бэрх, тунгалаг бус, хөдөлгөөнт, асар их шилжилт хөдөлгөөнтэй, цахимжилтын нөхцөлд өөр өнгө аястай болж байгаа билээ.

Монголд 1990 оноос социалист төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагаас зах зээлийн тогтолцоонд шилжснээр албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудал үүсч анхны судалгаанууд 1990-д оны дунд үеэс эхэлсэн юм. Жеймс Х. Андерсон, Елизабет Моррис, Билл Бикалис болон Хүрэлбаатар нар 1990-ээд оны сүүл болон 2000 оны эхэн үеэс Монголын албан бус хөдөлмөрийн болон жижиг бизнесийн талаар анхны судалгаа хийсэн.

Ж.Х. Андерсон болон хамтран ажилласан судлаачид Монголд шилжилтийн эдийн засагт албан бус хөдөлмөр эрхлэлт, жижиг бизнесийн үүргийг судлахад томоохон хувь нэмэр оруулсан. Тэдний судалгаа 1996-1997 онуудад Улаанбаатар хотод микро-үйлдвэрлэл, жижиг бизнесийн хэрхэн ажиллаж байгааг нарийвчлан судалсан. Шилжилтийн үеийн албан

бус салбарын талаарх ойлголтыг бий болгохын тулд Улаанбаатар хотын 770 албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дунд судалгаа явуулж, үндэсний өрхийн статистик мэдээлэлтэй нэгтгэж, эклектик хандлагыг баримталсан болно (Anderson, 1998). Энэ нь худалдаа, такси үйлчилгээ, гар урлал, жижиглэн худалдааны чиглэлээр голлон үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийг хамарсан юм. Судалгаагаар, албан бус хөдөлмөр эрхлэлт нь 1990-ээд оны сүүл гэхэд Улаанбаатар хотын ажиллах хүчний 30%-ийг бүрдүүлж байсныг онцолсон. Жижиг бизнесүүдийн зарим нь ядуурлыг бууруулахад тусалсан ч эдгээр ажилчид нь хууль зүйн хамгаалалтгүй, татварын дарамтанд орсонг илрүүлэн эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал болгосон.

Б.Бикалес, Д.Хүрэлбаатар нар Монголын албан бус хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн шилжилтийн чиглэлээр томоохон судалгаа хийсэн. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн хөдөлмөрийн статистикийн дүн шинжилгээ, хээрийн судалгаа, эдийн засгийн ижил төстэй шилжилтийг хийж буй бусад улс орнуудтай харьцуулсан судалгаанаас бүрдсэн. Тэдний үзэж буйгаар 1990-ээд оны эдийн засгийн шилжилт нь бүтцийн өөрчлөлт, хувьчлалаас шалтгаалж албан бус салбар огцом өссөн. Албан бус эдийн засаг нь хөдөөгийн хүн ам, ажилгүйчүүдийн орлогын чухал эх үүсвэр болсон. Уян хатан эдийн засгийн хэрэгцээ нь албан бус салбарыг зайлшгүй шаардлагатай болгосон. Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлтийн өсөлт нь зөвхөн эдийн засгийн шинэчлэлийн үр дагавар төдийгүй мал аж ахуй зэрэг түүхэн соёлын үйл ажиллагааны үр

дагавар байв. Албан бус эдийн засгийг зохицуулахын тулд албан ёсны болгох хөшүүргийг бий болгох зэрэг цогц арга барил шаардлагатайг тэмдэглэсэн (Bikales, B., C. Khurelbaatar and K. Schelzig., 2000).

Э.Моррисын ОУХБ-ын (Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага) хийсэн судалгаагаар: “Тооцоолсон хэмжээний зарим мэдэгдэхүйц ялгаа байгаа ч шилжилтийн эдийн засагт албан бус салбар чухал үүрэг гүйцэтгэдэг нь тодорхой байна. Тэрээр бусад зүйлсийн дотор илүүдэл ажилчид, улирлын ажилгүйчүүд, шинээр ажлын талбарт гарагч болон “нэмэлт ажилчид”-ыг өөртөө шингээдэг. Албан бус салбарын өсөлт нь төрийн өмчит үйлдвэрийн газруудын цомхотгол, хувьчлал, эдийн засгийн үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлт, өргөн хэрэглээний барааны үр ашигтай эрэлтийн өөрчлөлт, хөдөө орон нутгаас аймгийн төв, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний үр дүн юм. Тэдний олонх нь албан салбараас нүүлгэн шилжүүлсэн дунд насны ажилчид, дөнгөж ажилд орж буй залуу ажилчид юм. Албан бус эдийн засгийн бүх салбарт эмэгтэйчүүд зонхилж байна. Бүртгэлтэй ажил хайгчидтай харьцуулахад албан бус салбарын ажилчид өндөр боловсролтой байдаг. Энэ нь гэр бүлийн орлого олох, бага цалингаа нэмэх өөр боломж байхгүйтэй холбоотой байж болох юм. Албан бус салбар нь оршин тогтнох стратеги, бизнесийн боломжийг санал болгодог: энэ нь амьжиргаа эсвэл бичил аж ахуйн нэгжийг төлөөлдөг” (Morris, 2001, хууд. p.ix).

Эдгээр судалгаанууд нь Монгол дахь албан бус секторын динамик, түүний дотор эдийн засаг, нийгэм, соёлын талыг ойлгох үндэс суурийг

тавихийн зэрэгцээ 1990 оноос хойш Монгол Улсын хүн амын албан бус хөдөлмөр эрхлэлт амьдралын салшгүй хэсэг, орлогын эх үүсвэр болсныг харуулан Монголын албан бус хөдөлмөр эрхлэлтийн шинж чанарыг тодорхойлж, бодлого боловсруулагчдад чухал мэдээлэл өгсөн юм.

Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлт эхэлж байхад хөдөлмөр эрхлэлтийн талаарх илэрсэн дэлхийн нийт хандлагын талаар нэрт социологич З.Бауман анхааруулсан аж. Дараах дурьдсан эх сурвалж бидний судалгааны онолын суурь болсон болой.

XXI зууны тодорхойгүй “Урсгалт, шингэн” нөхцөл байдлыг Польш, Английн нэрт эрдэмтэн З.Бауман дүрслэхдээ хөдөлмөр болон баялгийн уялдаа холбоог нарийн гаргасан аж. (Bauman Z.,2002). Тэрээр орчин үед “Улс хоорондын худалдааны сэдэв нь эцсийн бүтээгдэхүүн биш, харин асуудлыг тодорхойлох (маркетинг, сурталчилгаа, хэрэглэгчийн зөвлөгөө), тэдгээрийг шийдвэрлэх (шинжлэх ухааны судалгаа, бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэл) болон зуучлал (санхүүжилт, хайлт, гэрээ байгуулах) зэрэг үйлчилгээ түүнчлэн уламжлалт шинж чанартай зарим бүрэлдэхүүн хэсэг, үйлчилгээнүүд бөгөөд энэ бүхэн хамтдаа бүтээгдэхүүний үнэ цэнийг бий болгодог юм. Хөдөлмөр, баялгийн байсан нарийн холбоо энэ зуунд ажиллаж чадахгүй болсонг суурьтай үндэслэн тэрээр албан бус эрхлэлтэд Р.Рэйхын ангилалыг ашигласан болно (Reich, 1991). Үүнд:

Роберт Рэйхын өнөөдөр эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийг болзолтойгоор дөрвөн том

ангилалд хуваахыг санал болгов.

“Бэлгэ тэмдгийн манипуляторууд”, өөрөөр хэлбэл тэдгээрийг хэрэгцээтэй, эрэлт хэрэгцээтэй зүйл болгон хувиргах санаа, арга замыг гаргаж ирсэн хүмүүс эхний ангиллыг бүрдүүлдэг.

Хоёрдахь ангилалд ажиллах хүчний нөхөн үржихүйн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс (боловсролын салбарын ажилтнууд эсвэл халамжийн төрийн албан хаагчид) багтдаг.

Гурав дахь нь “хувийн үйлчилгээ” чиглэлээр ажилладаг хүмүүс (Жон О’Нил “сайн гар урлал” гэж тодорхойлсон эдгээр төрлийн үйл ажиллагаанд), үйлчилгээ хүлээн авагчидтай хувийн харилцаа тогтоох шаардлагатай байдаг: тодорхой барааны худалдаачид. мөн тэдний эрэлтийг бүтээгчид энэ ангиллын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг.

Эцэст нь, дөрөв дэх ангилалд сүүлийн зуун хагасын хугацаанд хөдөлмөрийн хөдөлгөөний “нийгмийн субстрат” -ыг бүрдүүлсэн ердийн ажилчид багтдаг. Эдгээр нь хамгийн их тоогоор тэлэх чадвартай хүмүүс бөгөөд эдийн засгийн системийн хялбархан хүрч, сольж болох элементүүд болж хувирдаг. Тэдэнд тавигдах шаардлага нь үйлчлүүлэгчидтэй харилцах тусгай ур чадвар, урлагийг илэрхийлдэггүй тул ийм хүмүүсийг солиход хамгийн хялбар байдаг тул тэдний наймаа хийх чадвар (хэрэв байгаа бол) үлдэгдэл, үүнээс гадна үл тоомсорлодог. Тэд өөрсдийгөө бүрэн солих боломжтой гэдгээ ойлгодог тул ажлын байран дээрээ хатуу хавсарч, өөрсдөдөө аливаа үүрэг хариуцлага үүрүүлж, хамт ажиллагсадтайгаа ойр дотно харилцаатай байх нь утгагүй юм. Тэд ерөнхийдөө ажлын байран дээрээ тууштай байх эсвэл амьдралын зорилгоо ирээдүйтэй нь холбоход

сэжиглэх хандлагатай байдаг.

Орчин үеийн Монгол дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийг бид энэ онолын үүднээс шинжлэн эхлээд тэдний сэтгэл ханамж, нийгмийн харилцаа, арга барилыг авч үзэн ажлын онцлогт шинжилгээ хийсэн болно.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа олон шатат, санамсаргүй түүврийн аргыг түүвэр тооцох тэнцүү төлөөллийн аргатай хослуулан хэрэглэсэн. Түүвэрлэлтийн эхний шатанд Монгол улсын газар нутгийн бүсчлэл, хүн амын харьцаанд үндэслэн баруун бүсээс Увс аймгийг, хангайн бүсээс Өвөрхангай аймгийг, төвийн бүсээс Дархан аймгийг, зүүн бүсээс Дорнод аймгийг, урд чиглэлээс Дорноговь аймгийг, Улаанбаатар хотоос Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх дүүргээс мэдээлэл авч хоёрдугаар шатанд сонгогдсон аймгаас аймгийн төв болон сумдын газар зүйн байршил буюу аймгийн

төвөөс алслагдсан байдлыг харгалзан тус бүр хоёр сумыг сонгов.

Гуравдугаар шатанд Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сонгохдоо дараах 4 шалгуурын дагуу авч үзсэн болно. Үүнд: а)тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч; б)албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч; в) зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч; г) хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно. Ингэхдээ дараах салбарын хөдөлмөр эрхлэгчдийг судалгаанд хамруулсан болно.

Хүснэгт 1. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажил хөдөлмөр эрхлэлтийн салбар, хүрээ

№	Салбар	Ажил эрхлэлтийн хүрээ
1	Хоол, хүнс үйлдвэрлэл	Цайны газар ажиллуулдаг, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тогооч, зөөгч, угаагч, савлагч, жижүүр, камер харагч г.м
2	Худалдаа наймаа, үйлчилгээ	Худалдаа наймаа эрхэлдэг, дэлгүүр, ТҮЦ, ломбард ажиллуулдаг, худалдагч, кассчин, бараа нийлүүлэгч, утас зардаг, тавилгын үйлдвэрлэл/худалдаа эрхэлдэг, сүлжээний бизнес эрхэлдэг, койн, буудал, утас зардаг, авто машин зардаг, бараа нийлүүлэгч, агуулахын нярав г.м
3	ХАА-н үйлчилгээ, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа	Туслах малчин, малын түүхий эд боловсруулах/зарах, ногоочин, жимс жимсгэнэ тариалдаг, самар, жимс түүдэг, алт жоншинд явдаг
4	Ахуй үйлчилгээ	Үсчин, гоо сайханч, хумс засалч, айлын гэр цэвэрлэдэг, угаадаг, зурагчин, гутал засдаг, дархан, машин угаадаг, биллгярд тоглуулдаг, дархан
5	Хөнгөн үйлдвэрлэл	Оёдол, хувцас оёдог, гар урлал
6	Засвар үйлчилгээ	Утас засвар, авто засвар, дугуй засвар, засварчин, сантехникч, замчин
7	Барилга угсралт	Токарчин, гагнуурчин, барилгачин, засал чимэглэлч, мужаан, газар шорооны ажил хийдэг

8	Тээврийн үйлчилгээ	Таксинад явдаг, ачаар тээвэрт явдаг, жолооч
9	Оюуны үйл ажиллагаа	Хэлмэрч, орчуулагч, багш, ня-бо, технологч, лам, үзмэрч, ICT мэдээллийн ажилтан, үл хөдлөх хөрөнгө зуучлагч, СӨХ дарга, менежер
10	Эрүүл мэндийн үйлчилгээ	Хүүхэд асрагч, бариач, сувилагч

Судалгааны цар хүрээ, онолын үндэслэл зохиогчдын бусад нийтлэлд тусгагдсан тул энд дурдахгүй

болно. Эхлээд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сэтгэл ханамжийг авч үзье.



Тайлбар: Дундаж үзүүлэлтийн 1-5 баллаар эрэмбэлсэн. (Маш муу-1, муу-2 дунд-3, их-4, маш их -5)

Албан бус салбарт ажил эрхлэгчдийн хувьд өөрийн бүхий л амьдралдаа сэтгэл ханамжтай гэж хариулсан дундаж үзүүлэлт 3.07 буюу дунджаас дээгүүр байсан юм. Үүнд:

- ✓ Гэр бүлийн харилцаа-3.50,
- ✓ Хоол хүнсний хангамж-3.29,
- ✓ Ахуйн амьдралын тав тух-3.22,
- ✓ Орон сууцны нөхцөл, чанар-3.21,
- ✓ Нэр хүнд-3.20,
- ✓ Хувиин аюулгүй байдал-3.13 зэрэг үзүүлэлт эерэг нөлөө үзүүлж байна.

Харин дунджаас доогуур буюу муу гэж үнэлэгдсэн үзүүлэлтүүдийг дор дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн байдал – 2.99,
- ✓ Санхүүгийн байдал - 2.9,
- ✓ Чөлөөт цаг гарах боломж - 2.9,
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж - 2.88,
- ✓ Ах дүүс, найз нөхөдтэй хамт цагаа өнгөрөөх – 2.77,
- ✓ Амрах, аялах боломж - 2.73,
- ✓ Боловсрол мэдлэг авах боломж - 2.73 зэрэг болно.


Энэхүү сэтгэл ханамжийн үзүүлэлтэд хариулсан байдлаас харахад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ахуйн амьдралын тав тухын талаарх сэтгэл ханамж орон сууцны нөхцөл, чанарын талаарх сэтгэл ханамжтай харилцан



давхцах (multicollinearity) шинжтэй, харилцан бие биенээ орлох боломжтой үзүүлэлт болох нь харагдаж байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэгчдийн амьдралын сэтгэл ханамж илүү өндөр байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн хувьд 13 үзүүлэлтийн сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж арай өндөр байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд ердөө санхүүгийн байдал, хоол

хүнсний хангамж, амрах аялах боломж, ах дүүс, найз нөхөдтэйгөө хамт цагийг өнгөрөөх зэрэг дөрвөн үзүүлэлтийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт илүү байна. Эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн харилцаа, нэр хүнд, ахуйн амьдралын тав тух, хувийн аюулгүй байдал зэргийн сэтгэл ханамжийн үзүүлэлт илүү өндөр байв.

Зураг 2. Бусадтай харилцаатай байх, танил талын хүрээгээ өргөжүүлэхийг чухалчлах байдал, хувиар



Бусадтай харилцаа, танил талын хүрээгээ өргөжүүлэхэд ер нь анхаарал хандуулдаг гэж 36.7 хувь, чухалчилдаг ч ажил болгодоггүй гэж 26.1 хувь, 21.7 хувь нь их чухалчилж, санаа тавьдаг,

15.5 хувь нь ер нь анхаардаггүй байна. Эл үзүүлэлтийг чухалчлах байдал хүйсийн хувьд төдийлөн ялгаа ажиглагдсангүй.

Хүснэгт 2. Бусадтай харилцаатай байх, танил талын хүрээгээ өргөжүүлэхийг чухалчлах байдал, ажил, үйлчилгээний хэлбэрээр, хувиар

Ажил, үйлчилгээний хэлбэр	Их чухалчилж, санаа тавьдаг	Ер нь анхаарал хандуулдаг	Чухалчилдаг ч ажил болгодоггүй	Ер нь анхаардаггүй	Нийт
Хоол, хүнс үйлдвэрлэл	22.4	27.1	35.3	15.3	100.0
Худалдаа наймаа, үйлчилгээ	<b>25.1</b>	33.1	26.9	14.9	100.0
ХАА-н үйлчилгээ, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа	<b>27.6</b>	39.4	22.8	10.2	100.0
Ахуй үйлчилгээ	<b>24.0</b>	36.0	23.3	16.7	100.0
Хөнгөн үйлдвэрлэл	17.1	31.4	40.0	11.4	100.0
Засвар үйлчилгээ	12.7	46.0	17.5	<b>23.8</b>	100.0
Барилга угсралт	20.7	48.3	20.7	10.3	100.0
Тээврийн үйлчилгээ	16.7	31.3	30.2	<b>21.9</b>	100.0
Оюуны үйл ажиллагаа	10.6	53.0	22.7	13.6	100.0
Эрүүл мэндийн үйлчилгээ	16.0	36.0	32.0	16.0	100.0
Ажилгүй	22.7	36.4	22.7	18.2	100.0

Албан бус хөдөлмөр эрхлэгчдээс ХАА-н үйлчилгээ, байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа (27.6%), худалдаа наймаа, үйлчилгээ (25.1%), ахуй үйлчилгээ (24%) салбарынхан

их чухалчил санаа тавьдаг байна. Харин засвар үйлчилгээ, тээврийн үйлчилгээний салбарынхан 21.9-23.8 хувь нь ер нь анхаардаггүй гэсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Хүснэгт 3. Бусадтай харилцаатай байх, танил талын хүрээгээ өргөжүүлэхийг чухалчлах байдал, ажлын байранд гүйцэтгэж буй үүргээр, хувиар

Ажлын байранд гүйцэтгэж буй үүргээр	Их чухалчилж, санаа тавьдаг	Ер нь анхаарал хандуулдаг	Чухалчилдаг ч ажил болгодоггүй	Ер нь анхаардаггүй	Нийт
Ажил олгогч	16.5	57.1	13.2	13.2	100.0
Цалинтай ажиллагч	19.2	32.9	30.8	17.1	100.0
Өөрөө өөртөө ажил олгогч	25.4	36.6	23.8	14.2	100.0

Ажлын байранд гүйцэтгэж буй үүргээр нь харьцуулахад өөрөө өөртөө ажил олгогч албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 25.4 хувь нь их чухалчилж, санаа тавьдаг гэсэн нь бусад 2 бүлгээс хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

Ажил олгогч хоёр хүн тутмын нэг нь ер нь анхаарал хандуулдаг гэжээ. Харин цалинтай ажиллагчдын 17.1 хувь нь ер нь анхаардаггүй гэж хариулсан нь бусад хоёр бүлгийнхээс илүү байв.

Зураг 3. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн харилцаа, хувиар



Судалгаанд оролцсон хөдөлмөр эрхлэгчдийн цөөн хувь нь хүмүүстэй

харилцахыг хүсдэггүй, ганцаараа байхыг чухадчилдаг хүмүүс байв.



Харин талаас илүү хувь нь бусадтай уулзаж нийгмийн харилцаанд оролцох сонирхолто хүмүүс байв. Тухалбал, оролцогчдын 24.2 хувь нь өдөрт тутамдаа уулзаж мэдээлэл солилцдог, 28.8 хувь нь ер нь бусадтай холбогддог байна. Хүйсээр нь харьцуулан харахад өдөр тутам мэдээлэл солилцдог, бусадтай уулздаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс арай илүү байлаа. Харин хүмүүстэй уулзаж холбогддог ч тогтмол холбоотой байхыг эрмэлздэггүй гэж хариулсан эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс 7.1 хувиар илүү байсныг дурдах нь зүйтэй.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн оролцоог үйл ажиллагаанд оролцож буй байгууллагаар нь тодорхойлсон болно. Судалгааны дүнгээр судалгаанд оролцогчдын 16.9 хувь нь улс төрийн нам, 11.0 хувь нь олон нийтийн буюу төрийн бус байгууллагын, 8.5 хувь нь шашны байгууллагуудын, 7.4 хувь нь буяны байгууллага, сайн дурын үйл ажиллагаанд тус тус оролцдог гэжээ.

Оролцож буй байгууллагаар нь харахад хөдөөгийн хөдөлмөр эрхлэгчдийн оролцоо арай өндөр байгаа нь дээрх зургаас харагдаж байна. Харин ганц улс төрийн намын үйл ажиллагаанд оролцогчид хотод хөдөөгийнхөөс илүү байлаа. Түүнчлэн аливаа байгууллагын үйл ажиллагаанд

оролцдоггүй гэж хариулсан иргэдийн хувь хотод хөдөөгийнхөөс 12.4 хувиар илүү байв. Байгууллага, бүлгийн гишүүнчлэлийн хувьд оролцогчдын 71.8 хувь нь гишүүнчлэлгүй байв. Гишүүнчлэлтэй оролцогчдыг тодруулбал, улс төрийн нам (МАН, АН, Хүн нам), тогоочийн холбоо, шашны байгууллага, сүм, Ротари клуб, газар тариаланчдын холбоо гэх мэт юм.

Эх сурвалжийн шинжилгээ хийсний үр дүнд албан бус сектор, хөдөлмөр эрхлэх онолын хэсэгт санал болгосон Роберт Рэйхын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүсийг болзолтойгоор дөрвөн том ангилалд хуваахыг санал болгоны дагуу асуулт боловсруулж шинжилсэн үр дүнг толилуулав. Дахин сануулахад эдгээрт:

“Бэлгэтэмдгийн манипуляторууд”, өөрөөр хэлбэл тэдгээрийг хэрэгцээтэй, эрэлт хэрэгцээтэй зүйл болгон хувиргах санаа, арга замыг гаргаж ирсэн хүмүүс эхний ангиллыг бүрдүүлдэг.

Хоёрдахь ангилалд ажиллах хүчний нөхөн үржихүйн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс (боловсролын салбарын ажилтнууд эсвэл халамжийн төрийн албан хаагчид) багтдаг.

Гурав дахь нь “хувийн үйлчилгээ” чиглэлээр ажилладаг хүмүүс.

Дөрөв дэх ердийн ажилчид багтдаг.

Хүснэгт 4. Таны ажил хөдөлмөр дараах шинж чанар хэр зэрэг агуулдаг вэ?

№	Сонголтууд	Маш их (5)	Их талдаа (4)	Дунд зэрэг (3)	Үгүй талдаа (2)	Огт үгүй (1)	Дундаж (1-5)
1	Шинэ санаа, мэдлэг бүтээдэг	8.1	16.6	32.1	20.4	22.9	2.67
2	Бүтээгдэхүүн гаргах эсвэл бусдын хийсэн зүйлийг хувиргадаг (зураг, ТЭЗҮ, тайлан гаргах г.м)	3.9	17.1	24.3	25.1	29.6	2.40
3	Цахим орчинд контент бүтээдэг	3.3	9.1	26.3	22.0	39.3	2.15
4	Манлайлагч, бусдыг дагуулдаг, нөлөөлдөг	4.4	13.7	30.0	23.6	28.3	2.42
5	Бусдыг санаа, мэдлэгийг түгээдэг, үүгээр үйлчилдэг (багш, эмч мэт)	2.3	15.8	23.9	22.0	36.1	2.26
6	Зуулчлал үзүүлдэг	5.5	12.2	25.9	24.1	32.3	2.34
7	Хувийн үйлчилгээ үзүүлдэг (гар урлал, асаргаа, жолооч, хамгаалал, худалдаачид г.м.)	12.6	19.7	26.9	19.8	21.1	2.83
8	Биеийн хүч шаардсан	11.8	20.2	29.9	18.4	19.8	2.86
9	Нарийн чадамж, туршлага шаардахгүй	8.3	19.1	29.6	22.0	21.1	2.72

Судалгаанд оролцогсад эрхэлдэг хөдөлмөрийнхөө хамгийн их шаардлагатай шинж чанарыг дараах байдлаар тодорхойлов. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 24,7% нь шинэ санаа, мэдлэг бүтээдэг, 21% бүтээгдэхүүн гаргах эсвэл бусдын хийсэн зүйлийг хувиргадаг (зураг, ТЭЗҮ, тайлан гаргах г.м), 12,4% нь цахим орчинд контент бүтээдэг, 18,1% манлайлагч, бусдыг дагуулдаг, нөлөөлдөг, 18.1% бусдыг санаа, мэдлэгийг түгээдэг, үүгээр үйлчилдэг (багш, эмч мэт), 17.7% зуулчлал үзүүлдэг, 32.3% хувийн үйлчилгээ үзүүлдэг (гар урлал, асаргаа, жолооч, хамгаалал, худалдаачид г.м.), 32% биеийн хүч шаардсан, 27.4% нарийн чадамж, туршлага шаардахгүй ажил хийдэг байна. Хөдөлмөр эрхлэлтийн

байдлаар хүчин зүйлсийн шинжилгээ хийлээ. Шинжилгээний найдвартай байдлыг үзэхэд дараах үр дүнгээр буюу 0.862 батлагдав.

Хүснэгт 5. KMO and Bartlett's Test

Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.862
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square df	3350.534
	Sig.	.000

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд судалгаанд оролцсон албан бус хөдөлмөр эрхлэгчид 2 бүлэгт буюу бүтээлч (дээрх Р.Рейхын ангиллын дагуу бүтээлч болон бидний асуулгын дагуу эхний 6 шинж чанарт өөрийгөө хамруулсан) болон гүйцэтгэгч болох сүүлийн 3 шинж чанарт тодорхойлогдсон хэмээн хуваагдсан юм.

*Хүснэгт 6. Ажил, хөдөлмөр эрхлэлтийн шинж чанарын хүчин зүйлийн шинжилгээний үр дүн*

	Сонголтууд	Component	
		1	2
1	Шинэ санаа, мэдлэг бүтээдэг	.803	
2	Бүтээгдэхүүн гаргах эсвэл бусдын хийсэн зүйлийг хувиргадаг (зураг, ТЭЗУ, тайлан гаргах г.м)	.798	
3	Цахим орчинд контент бүтээдэг	.768	
4	Манлайлагч, бусдыг дагуулдаг, нөлөөлдөг	.759	
5	Бусдыг санаа, мэдлэгийг түгээдэг, үүгээр үйлчилдэг (багш, эмч мэт)	.733	
6	Зуулчлал үзүүлдэг	.628	
7	Хувийн үйлчилгээ үзүүлдэг (гар урлал, асаргаа, жолооч, хамгаалал, худалдаачид г.м.)		.774
8	Биеийн хүч шаардсан		.739
9	Нарийн чадамж, туршлага шаардахгүй		.726

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих үед албан бус бизнес эрхлэх үйл ажиллагаа тэсрэлт болсон нь өргөн уудам газар нутагтай боловч хүн ам сийрэг суурьшсан Монгол өөрчлөлтийн хамгийн тод шинж тэмдэгүүдийн нэг юм гэсэн анхдагч судалгааны үр дүн байв. 20-иод жилийн дараах албан бус хөдөлмөр эрхлэгчдийн судалгааны үр дүнгээс харахад албан бус хөдөлмөр эрхлэлт нь зөвхөн амьжиргаа залгуулахаас өөр олон хэлбэрт шилжлсэн байна.

Наад зах нь сэтгэл ханамжийн үзүүлэлтэд хариулсан байдлаас харахад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд ахуйн амьдралын тав тухын талаарх сэтгэл ханамж орон сууцны нөхцөл, чанарын талаарх сэтгэл ханамжтай харилцан давхцах шинжтэй, харилцан бие биенээ орлох боломжтой үзүүлэлт болох нь харагдаж байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэгчдийн амьдралын сэтгэл ханамж илүү өндөр байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн хувьд 13 үзүүлэлтийн сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж арай өндөр байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд ердөө санхүүгийн байдал, хоол хүнсний хангамж, амрах аялах боломж, ах дүүс, найз нөхөдтэйгөө хамт цагийг өнгөрөөх зэрэг дөрвөн үзүүлэлтийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт илүү байна. Эмэгтэйчүүдийн хувьд

гэр бүлийн харилцаа, нэр хүнд, ахуйн амьдралын тав тух, хувийн аюулгүй байдал зэргийн сэтгэл ханамжийн үзүүлэлт илүү өндөр байв.

Бидний дэвшүүлсэн ангиллын бас нэг шалгуур бол бусадтай харилцах онцлог байв. Албан бус хөдөлмөр эрхэгчдийн хувьд оюуны хөдөлмөр бүтээлчийн хувьд илрэх онцлог илрэв. Судалгаанд оролцсон хөдөлмөр эрхлэгчдийн цөөн хувь нь хүмүүстэй харилцахыг хүсдэггүй, ганцаараа байхыг чухадчилдаг хүмүүс байв. Харин талаас илүү хувь нь бусадтай уулзаж нийгмийн харилцаанд оролцох сонирхолто хүмүүс байв. Тухалбал, оролцогчдын 24.2 хувь нь өдөр тутамдаа уулзаж мэдээлэл солилцдог, 28.8 хувь нь ер нь бусадтай холбогддог байна. Хүйсээр нь харьцуулан харахад өдөр тутам мэдээлэл солилцдог, бусадтай уулздаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс арай илүү байлаа.

Дүгнэхэд Р.Рейхын онол арга зүйн дагуу судалгааны арга зүй боловсруулж шинжилж үзэхэд орчин үед шилжилтийн үедэх амьжиргаа залгуулах албан бус хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хальж сонирхлын дагуух болон оюуны ажил хийх сонирхол нэмэгдсэн байна.

- Geertz, C. 1963. *Peddlers and Princes: Social Change and Economic Modernization in Two Indonesian Towns*. Chicago: [University of Chicago](#) Press.
- Hart, K. [1971] (1973). Informal income opportunities and urban employment in Ghana. *The Journal of Modern African Studies*, 11(1), 61–89.
- Anderson, J. H. (1998). *The Size, Origins, and Character of Mongolia's Informal Sector During the*. Washington, DC: Policy Research Dissemination Center, the World Bank.
- Bikales, B., C. Khurelbaatar and K. Schelzig. (2000). *MONGOLIAN URBAN INFORMAL SECTOR*. Retrieved from Economic Policy Support Project. Development Alternatives Inc.: [http://www.forum.mn/res\\_mat/The%20Mongolian%20Informal%20Sector.pdf](http://www.forum.mn/res_mat/The%20Mongolian%20Informal%20Sector.pdf)
- Morris, E. (2001). *The informal sector in Mongolia: Profiles, needs, and strategies*. Retrieved from Bangkok: International Labour Organization.: URL: [http://www.oit.org/wcmsp5/groups/public/---asia/--ro-bangkok/documents/publication/wcms\\_bk\\_pb\\_105\\_en.pdf](http://www.oit.org/wcmsp5/groups/public/---asia/--ro-bangkok/documents/publication/wcms_bk_pb_105_en.pdf)
- Union, E. (1997). *Luxembourg Declaration on Workplace health promotion in the European Union*. Luxembourg .
- Bauman Z. (2002). *Индивидуализированное общество*. “Logos”.
- Reich, R. B. (1991). *The work of nations: Preparing ourselves for 21st-century capitalism*. A.A. Knopf.
- Theories and definitions of the Informal Economy: A Survey*. (n.d.). Retrieved August 8, 2022, from <https://onlinelibrary.wiley.com/>